



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/105/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Намжил Утас: 70453721, Цахим хаяг: NamjiIT@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	3
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТАРИАЛАН СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Х.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

2022.02.25 № ЦУВА - 2022/105/НА - СТА - ТШЭ
танай - ны № -Т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200700272

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,683,893.00	23,122,493.00
34	УРЬДЧИЛГАА		0
34600	Урьдчилж гарсан зардал		0
35	БАРАА МАТЕРИАЛ	19,683,893.00	23,122,493.00
35100	Түүхий эд материал		
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
35400	Хангамжийн материал	19,683,893.00	23,122,493.00
35410	Бичиг хэргийн материал	239,500.00	209,600.00
35420	Аж ахуйн материал	11,484,693.00	11,484,693.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	7,959,700.00	11,428,200.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	659,826,267.07	638,947,974.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	659,826,267.07	638,947,974.70
39100	Газар		
39200	Биет хөрөнгө	656,822,267.07	635,943,974.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	601,725,000.00	601,725,000.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,463,380.64	-44,195,070.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0	0
39204	Хуримтлагдсан элэгдэл	0	0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	67,892,982.50	67,892,982.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-47,168,113.50	-50,673,575.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,532,280.00	38,532,280.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	24,350,185.29	-26,991,325.38
39209	Зам, гүүрийн байгууламж		0
39210	Хуримтлагдсан элэгдэл		0
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		0
39212	Хуримтлагдсан элэгдэл		0
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	43,219,850.00	43,219,850.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	861,340.00	861,340.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		0

39216	Дуусаагүй барилга, байгууламж		0
39217	Ном	5,572,494.00	5,572,494.00
39300	Биет бус хөрөнгө	3,004,000.00	3,004,000.00
39301	Програм хангамж		0
39302	Хуримтлагдсан элэгдэл		0
39303	Бусад биет бус хөрөнгө	8,004,000.00	8,004,000.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	-5,000,000.00	-5,000,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	679,510,160.07	662,070,467.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,119,127.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,119,127.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	657,391,033.07	662,070,467.70
51	Засгийн газрын хувь оролцоо	657,391,033.07	662,070,467.70
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	79,508,493.00	79,508,493.00
51200	Хуримтлагдсан үр дүн	139,443,142.61	144,122,577.24
51210	Өмнөх үеийн үр дүн	139,443,142.61	139,443,142.61
51220	Тайлант үеийн үр дүн		4,679,434.63
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	438,439,397.46	438,439,397.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	679,510,160.07	662,070,467.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	155,800,079.48	134,016,145.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,998,579.48	974,545.48
120	Нийтлэг татварын бус орлого	25,998,579.48	974,545.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,998,579.48	974,545.48
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,054,545.48	974,545.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,494,4034.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	24,944,034.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	129,801,500.00	133,041,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	0	3,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	129,801,500.00	130,041,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	129,801,500.00	130,041,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	152,117,772.57	129,336,710.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	152,117,772.57	129,336,710.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	126,668,047.09	127,480,108.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,517,990.00	62,097,528.00
210101	Үндсэн цалин	57,477,990.00	57,057,528.00
210102	Нэмэгдэл		0
210105	Гэрээтийн цалин	5,040,000.00	5,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,788,068.00	8,063,711.00

Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	5,324,750.00	5,585,003.00
210202	Тэтгэмжийн даатгал	618,527.00	620,976.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	500,124.00	496,780.00
210204	Ажилгүйдлийн даатгал	122,265.00	123,325.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,222,402.00	1,237,627.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,391,627.00	32,782,077.00
210301	Гэрэл, цахилгаан	326,378.00	337,189.00
210302	Түлш, халаалт	29,065,249.00	32,444,888.00
210303	Цэвэр, бохир ус		0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,909,400.00	739,500.00
210401	Бичиг хэрэг	365,800.00	233,600.00
210402	Тээвэр, шатахуун	881,600.00	255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	199,900.00
210404	Ном, хэвлэлийн зардал	58,000.00	21,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	244,000.00	30,000.00
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал	560,000.00	0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	560,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,843,300.00	1,081,000.00
210601	Багаж хэрэгсэл	300,000.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0	82,500.00
210604	Урсгал засвар	1,543,300.00	998,500.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	122,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	122,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,039,000.00	1,716,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	949,000.00	1,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	90,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		0
210804	Тээврийн хэрэгслийн татвар		0
210807	Газрын төлбөр		0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,576,662.09	20,878,292.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,576,662.09	20,878,292.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,449,725.48	1,856,602.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,148,900.00	250,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		0

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,848,900.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,300,825.48	1,606,602.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,300,825.48	1,606,602.48
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,682,306.91	4,679,434.63
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,682,306.91	4,679,434.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	130,856,045.48	134,016,145.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,054,545.48	974,545.48
120	Нийтлэг татварын бус орлого	1,054,545.48	974,545.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,054,545.48	974,545.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	129,801,500.00	133,041,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	0	3,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	129,801,500.00	130,041,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт, орон нутгийн төсөвт байгууллага	129,801,500.00	130,041,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	130,856,045.48	134,016,145.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,856,045.48	134,016,145.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,406,320.00	132,159,543.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,517,991.00	62,097,528.00
210101	Үндсэн цалин	57,477,991.00	57,057,528.00
210102	Нэмэгдэл		0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		0

210104	Урамшуулал		0
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,776,802.00	8,063,711.00
210201	Тэтгэврийн даатгал	5,313,484.00	5,585,003.00
210202	Тэтгэмжийн даатгал	618,527.00	620,976.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	500,124.00	496,780.00
210204	Ажилгүйдлийн даатгал	122,265.00	123,325.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,222,402.00	1,237,627.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,391,627.00	54,901,204.00
210301	Гэрэл, цахилгаан	326,378.00	337,189.00
210302	Түлш, халаалт	29,065,249.00	54,564,015.00
210303	Цэвэр, бохир ус	0	0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,716,700.00	851,100.00
210401	Бичиг хэрэг	245,000.00	203,700.00
210402	Тээвэр, шатахуун	881,600.00	255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	199,900.00
210404	Ном хэвлэл	58,000.00	48,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	172,100.00	144,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	100,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	0
210502	Хоол, хүнс	0	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,720,200.00	1,308,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	230,000.00	83,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	82,500.00
210604	Урсгал засвар	1,490,200.00	1,142,500.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	122,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	122,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,741,000.00	4,716,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,651,000.00	4,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	0
210807	Газрын төлбөр	0	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0	0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0	0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,449,725.48	1,856,602.48
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		0

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,848,900.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн захирагчдад олгох татаас	1,300,825.48	1,606,602.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,300,825.48	1,606,602.48
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
2200	Дотоод эх үүсвэрээр		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	79,508,493.00	438,439,397.46	135,760,835.70	653708726.16
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	79,508,493.00	438,439,397.46	135,760,835.70	653,708,726.16
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			3,682,306.91	3,682,306.91
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,508,493.00	438,439,397.46	139,443,142.61	657,391,033.07

11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	79,508,493.00	438,439,397.46	139,443,142.61	657,391,033.07
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	79,508,493.00	438,439,397.46	139,443,142.61	657,391,033.07
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			4,679,434.63	4,679,434.63
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,508,493.00	438,439,397.46	144,122,577.24	662,070,467.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	130,041,600.00	129,409,543.00	632,057.00	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,041,600.00	129,409,543.00	632,057.00	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,791,600.00	129,159,543.00	632,057.00	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,145,000.00	62,097,528.00	47,472.00	99.9
210101	Үндсэн цалин	57,105,000.00	57,057,528.00	47,472.00	99.9
210102	Нэмэгдэл				
210104	Урамшуулал				
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00	0	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,389,600.00	8,063,711.00	325,889.00	96.1
210201	Тэтгэврийн даатгал	5,903,800.00	5,585,003.00	318,707.00	94.6
210202	Тэтгэмжийн даатгал	621,400.00	620,976.00	424.00	99.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	497,200.00	496,780.00	420.00	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	124,300.00	123,325.00	975.00	99.2
210205	Эрүүл мэндийн даатгал	1,242,900.00	1,237,627.00	5,273.00	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,118,400.00	54,901,204.00	217,196.00	99.6
210301	Гэрэл, цахилгаан	554,400.00	337,189.00	217,211.00	60.8
210302	Түлш, халаалт	54,564,000.00	54,564,015.00	-15.00	100
210303	Цэвэр, бохир ус	0	0		

Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	855,100.00	851,100.00	4000.00	99.5
210401	Бичиг хэрэг	204,100.00	203,700.00	400.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	255,000.00	255,000.00	0	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,200.00	199,900.00	300.00	99.9
210404	Ном хэвлэл	50,000.00	48,500.00	1,500.00	97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	144,000.00	1,800.00	98.8
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00	0	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	0		
210502	Хоол, хүнс	0	0		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,310,000.00	1,308,000.00	2,000.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	83,700.00	83,000.00	700.00	99.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,300.00	82,500.00	800.00	99
210604	Урсгал засвар	1,143,000.00	1,142,500.00	500.00	100
2107	Томилолт, зочны зардал	133,500.00	122,000.00	11,500.00	91.4
210702	Дотоод албан томилолт	133,500.00	122,000.00	11,500.00	91.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	240,000.00	1,716,000.00	1,476,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	1,500,000.00	1,350,000.00	-
210802	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	90,000.00	216,000.00	-126,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ				
210804	Тээврийн хэрэгслийн татвар				
210807	Газрын төлбөр				
	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00		1,500,000.00	0
	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00		1,500,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,000.00	250,000.00		
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг				
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	250,000.00		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал				
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал				

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж				
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	250,000.00		
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	130,041,600.00	131,016,145.48	-974,545.40	100.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
310001	Улсын төсвөөс санхүүжих				
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
	Орон нутгийн төсвөөс	130,041,600.00	130,041,600.00	0	100
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		974,545.48	-974,545.40	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,000,000.00	-3,000,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,000,000.00	3,000,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,000,000.00	3,000,000.00	
210901	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,000,000.00	3,000,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал				
210401	Бичиг хэрэг				
210402	Тээвэр, шатахуун				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал				
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210604	Урсгал засвар				
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
2132	Бусад урсгал шилжүүлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал				
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3,000,000.00	3,000,000.00	
31	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,000,000.00	3,000,000.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус		3,000,000.00	3,000,000.00	

	этгээдээс авсан хандив тусламж				
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого				

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тариалан сумын Соёлын төв нь Соёлын үнэт зүйлийг өвлөн хамгаалж түгээн дэлгэрүүлж бүх нийтэд соёл урлагийн боловсролыг эзэмшүүлж авьяас билгийг нээн хөгжүүлж орон нутгийн болон аймаг бүсийн хэмжээнд соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүргэж соёлын өв уламжлалыг хүүхэд залуучуудад сурталчлан таниулж өвлүүлэн үлдээхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 152,117.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,521.2 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 129,336.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 1,293.3 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тариалан сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,439.7 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	19,683.9	23,122.5	3,438.6
Үндсэн хөрөнгө	659,826.3	638,947.9	-20,878.3
Нийт хөрөнгө	679,510.1	662,070.4	-17,439.7
Өр төлбөр	22,119.1	0	-22,119.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	657,391.0	662,070.4	4,679.4

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	679,510.1	662,070.4	-17,439.7
---	-----------	-----------	-----------

Бараа материалын дансны үлдэгдэл 23,122.5 мянган төгрөг болж 3,438.6 мянган төгрөгөөр өссөн нь хандивын мөнгөөр авсан хувцас, 3,000.0 мянган төгрөгийг бусад хангамжийн материалд бүртгэж авсан нь голчлон нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 638,947.9 мянган төгрөг 20,878.3 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0 мянган төгрөг болж 22,119.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн түлш халаалтын өрийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 662,070.4 мянган төгрөг болж 4,679.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 21,783.9 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 24,944.0 мянган төгрөг байсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 22,781.0 мянган төгрөгөөр буурсанд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж голчлон нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 130,041.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 130,041.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хэвээр нь буюу 130,041.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 130,041.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 130,041.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 130,041.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 974.5 мянган төгрөг, нийт 131,016.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 129,409.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны данснаас 1,606.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 129,409.5 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжийн 3,000.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Үүнээс 3,000.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд байгууллага үйл ажиллагаанд шаардлагатай хувцас хэрэгсэл авч бусад хангамжийн материалд бүртгэж авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Тариалан сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 147, хугацаа хоцроож мэдээлсэн 2, мэдээлэх хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

2022 оны 02 сарын 22-ны өдөр